



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3.0 ТЭРБУМ ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
8.7%



НИЙТ ХАДГАЛАМЖ
11 ИХ НАЯД ТӨГ



ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС
1.015 НЭГЖ



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
801 ТЭРБУМ ТӨГ



ИПОТЕКИЙН ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО
258 ӨРХ

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +4.0%, 2018 онд: +3.0%

Инфляци: 2017 онд: +3.0%, 2018 онд: +3.4%

Урсгал тэнцэл: 2017 онд ДНБ-ий -6.4%, 2018 онд: -8.5%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zwQ36D>

ДНБ-ий өсөлт: 2017 онд: +2%, 2018 онд: +2.5%

Инфляци: 2017 онд: +4.4%, 2018 онд: +6%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2017 онд: -4.9%, 2018 онд: -8.7%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 1-р сарын байдлаар 114 тэрбумын ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 9.7 хувиар өсч, зарлага 10.7 хувиар буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 114 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 139 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 7.7 төгрөгөөр буурав.

Нэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 62 төгрөг буюу 2.5 хувиар буурч, өмнөх сартай харьцуулахад 7.7 төгрөг буюу 0.3 хувиар буурч 2425.77 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 3 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин нэмэгдсэн байна.




Инфляцийн түвшин 6.9 хувь

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 1-р сард өмнөх сараас 1.4 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, түлшний бүлгийн үнэ хамгийн их өсөхөд нөлөөлөв. 2018 он гарснаар төгрөгтэй харьцах юанийн ханш тогтмол чангарч, сар шинэтэй зэрэгцэн шатахууны үнэ нэмэгдсэн.




Гадаад худалдааны тэнцэл 62.7 сая.ам доллар болов.

2018 оны эхний нэгдүгээр сарын байдлаар нийт барааны эргэлт 784.9 тэрбум төгрөг буюу 11 хувиар өсөв. Экспорт өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурч, импорт өмнөх оны мөн үеэс 30 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 62.7 сая ам.долларын ашигтай гарлаа.



1-Р САРЫН ОНЦЛОХ: НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ЗАРЛАГА

Эх сурвалж: www.1212.mn

2017 оны 4-р улирлын байдлаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого (улсын дундаж) 1.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 126.1 (12%) мянган төгрөгөөр өсөв. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого өсөхөд цалин хөлсний орлого 47 (10.3%) мянган төгрөг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 28 (46.6%) мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2017 оны 4 дүгээр улиралд 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 148.8 (13.2%) мянган төгрөгөөр өслөө. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага өсөхөд хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага 103.4 (15.4%) мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Өрхүүдийг мөнгөн орлого, зарлагаар нь бүлэглэн авч үзвэл, 2017 оны 4 дүгээр улиралд 300 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 109.5 (12.3%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 73 (8.2%) мянга, 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 144.2 (16.2%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 138.8 (15.6%) мянга, 500-900 мянган төгрөгийн орлоготой өрх 289.2 (32.5%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 280 (31.5%) мянга байна. Харин 2.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 57.8 (6.5%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 70.3 (7.9%) мянга байна.

Нэг хүнд ногдох сарын дундаж бодит (үнийн нөлөөллийг арилган тооцсон) орлогын хэмжээ амьжиргааны доод түвшнээс улсын дунджаар 55.0 хувь, Төвийн бүсэд 72.8 хувь, Улаанбаатар хотод 65.7 хувь, Зүүн бүсэд 49.3 хувь, Хангайн бүсэд 32.5 хувь, Баруун бүсэд 31.4 хувиар тус тус өндөр байна.

Улсын хэмжээнд 2017 оны 4 дүгээр улиралд хамгийн ядуу бүлгийн хүн амын хэрэглээ нийт хэрэглээнд 7.2 хувийг, хамгийн чинээлэг бүлгийн хүн амын хэрэглээ 42 хувийг эзэлж байна. Энэ нь хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээний дундаж хэмжээ хамгийн ядуу 20 хувийнхнаас 5.8 дахин их байгааг харуулж байна.

САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ ӨСӨВ, ЧИНГИС БОНДЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ

- Олон улсын санхүүгийн үнэлгээний байгууллага "Moody's" агентлаг Засгийн газрын урт хугацааны зээлжих зэрэглэлийг Саа1 зэрэглэлээс В3 руу болгож өсгөв. Монгол Улсын Засгийн газрын зээлжих зэрэглэл өсөхөд нөлөөлж буй хүчин зүйлс нь гадаад өрийг төлөх чадвар, өрийн хэмжээ болон түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамааралтай зээлийн эрсдлийн үнэлгээ юм. Зээлжих зэрэглэл сайн байх нь хүү багатай мөнгө орж ирэх, зээлийн хүү нэг оронтой тоонд байх боломжтой. Гэхдээ Монгол Улсын хувьд түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэлтэй савлалтыг арилгахад үр нөлөөтэй байж болох ч зээл төлөх чадвар болон гадаад өрийн дарамт хэвээр үлдэж болзошгүй байна.
- 2012 онд Засгийн газрын үед 1.5 тэрбум ам.долларын Чингис бондыг олон улсын зах зээлд арилжаалсан. Тус үнэт цаасны эргэн төлөх хугацааны дагуу 2018 оны нэгдүгээр сарын 5-нд бондын эргэн төлөлт 500 сая ам.долларыг шилжүүлэв. 2023 онд 10 жилийн хугацаатай үлдсэн 1 тэрбум ам.долларын бондын эргэн төлөлтийг хийж дуусгах ёстой.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 1-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 1-р сар 2018 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn